

БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ.

М.ЖАМЬЯНШАРАВ

# БАТЛАМЖ

Бат-Өлзий сумын Засаг даргын өмнө 3 дугаар багийн Засаг даргаар томилогдсон С.Төмөр Миний бие багийнхаа хөгжлийг эрчимтэйгээр урагшлуулж, ард иргэдийнхээ зруул саруул, ажил орлоготой, ая тухтай амьдралыг бий болгохын төлөө өөрийн оюун билиг, мэдлэг, чадвар, сэтгэл, зүтгэлээ дайчлан зориулж, төр засгийн бодлого шийдвэрийг тууштай, шуурхай, шударга, хариуцлагатайгаар хэрэгжүүлэх үүднээс доорх үүрэг, зарчмуудыг мөрдлөгө болгон ажиллахаа батlamжилж байна.

1. Багийн иргэдийн нийтлэг эрх, ашиг сонирхлыг илэрхийлж, Монгол Улсын Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж ажиллана.
2. Засаг төрийн төлөөлөгчийн хувьд төрийн хууль ёсыг чандлан сахиж, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг мөрдөн ажиллана.
3. Иргэдийн оролцоотой төрийн үйлчилгээний шинэчлэлийг бүх салбарт тууштай нэвтрүүлж ажиллана.
4. Монгол Улсын Төсвийн тухай хуулийг чанд сахин хэрэгжүүлж, багийн нийгэм, эдийн засаг санхүүгийн чадавхийг сайжруулан, бүтээн байгуулалтыг өрнүүлэн ажиллана.
5. Багийн эдийн засгийн бодит өсөлтийг хангахын зэрэгцээ соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарын жигд хөгжлийг хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэн, ажилгүйдэл, ядуурлын түвшинг бодитой бууруулж ажиллана.
6. Өөрийн үйл ажиллагаанд Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мөрдлөг болгож, нийгмийн дэг журам, сахилга хариуцлагыг өндөржүүлэн, авлигаас ангид ажиллана.
7. Засгийн газрын шийдвэр, сумын ИТХ, Засаг дарга, удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлagnаж, дэмжлэг туслалцаа авч ажиллана.
8. Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшин нь шаардлага хангахгүй байгаа болон Төсвийн хууль зөрчсөн, албан тушаалаа хувийн зорилгодоо ашигласан, ашиг сонирхлын болон авлигын зөрчил, ёс суртахууны доголдол гаргасан, архидан согтуурсан тохиолдолд улс төрийн хариуцлага хүлээнэ.
9. Энэхүү батlamжаар хүлээсэн үүргээ хагас, бүтэн жил тутам сумын Засаг даргад тайлagnана.

Батlamж нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн багийн Засаг даргын бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэл хүчин төгэлдөр мөрдөгднө.

3 ДУГААР БАГИЙН ЗАСАГ ДАРГА

С.ТӨМӨР

2017.01.01. сарын 05.